



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.4.23 № 03/93

Зөрчил арилгуулах тухай

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрдээ. Үүнд:

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын аппаратын 2012 оны санхүүгийн тайлангаар 62.0 сая төгрөгийн авлага нь Солонгос улс дах нэг цэгийн үйлчилгээний байрны барьцаатай холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг өгч байна.

Дээрх 62.0 сая төгрөгийн авлагыг холбогдох байгууллагатай тооцоо нийлэн барагдуулж 2013 оны IV улиралд багтаан биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Мөнхзул болон хариуцсан албан тушаалтан, мэргэжилтэн нарт даалгав.

АУДИТОР



Б. ДАВААБААТАР